# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр Дугаар 295 Улаанбаатар хот

## Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.3, 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Консерваторийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлаж ашиглах боломжгүй болсон 13,300,000.00 (арван гурван сая гурван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий 1 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Монгол Улсын Консерваторийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Пүрэвхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 4 дүгээр улиралд багтаан мэдээ, тайлангийн баталсан маягтаар ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ц.ТҮВШИНЗАЯА

0000595

C:\2019.07.22 16г huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицу...
2019 оны 05 дугаар сарын 20-...
295 дугаар тогтоолын хавсра...

Монгол Улсын Консерваторийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

| ...шины марк, улсын ...ар, зориулалт, ...үр, арлын дугаар | Үйлдвэрлэсэн/ашиглалтад орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Сэргээн босголтын зардал | Х... |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | /төгрөгөөр/ | | | | |
| ...TREK, УНҮ 19-70, ...арал: ...DXB256082 | 1999/2011 | 185838 | 13,300,000.00 | 13,300,000.00 | - | 549,545 | |
| **...ит дүн** | | | **13,300,000** | **13,300,000** | - | **549,545** | |
| | | | **(арван гурван сая гурван зуун мянган)** | | | **(таван зуун дөчин есөн сая таван зуун дөчин таван)** | **(н... з...** |